

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОЖ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, активыг ангилах, эрсдэлийн сан байгуулж, зарцуулах болон үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

ХОЁР. БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1.Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд дараах нийтлэг шаардлага тавина:

2.1.1.банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн дүрэм, үйл ажиллагаа эрхлэхэд мөрдөх эрх зүйн баримт бичиг, үйлчилгээний нөхцөл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан байх;

2.1.2.эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигчээс оруулах мөнгөн хөрөнгө нь бусдын өмнө үүрэг хүлээгээгүй, тухайн этгээд, түүнтэй холбогдох этгээдийн хууль ёсны орлогоор бүрдүүлсэн, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнасан орлого байх;

2.1.3.Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх;

2.1.4.энэ журмын 2.1.2-т заасан шаардлага нь хувьцаат компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид мөн адил хамаарах ба компанийн нийт гаргасан хувьцааны 5-аас доош хувийн хувьцаа эзэмшигчид хамаарахгүй;

2.1.5.гүйцэтгэх захирал нь томилогдсоноос хойш 6 сарын дотор банк бус санхүүгийн чиглэлээр эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх;

2.1.6.банк бус санхүүгийн үйл ажиллагааг дэвшилтэт технологийн шийдлийг ашиглан үзүүлэх тохиолдолд хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан холбогдох шаардлагыг хангаж, ISO/IEC27001 стандартын гэрчилгээ авсан байх;

2.1.7.банк бус санхүүгийн үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү, шимтгэл, хураамжийн хэмжээг баталсан байх.

2.2.Банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээнд дараах шаардлага тавина:

2.2.1.Иргэний хуулийн 123 дугаар зүйлийг удирдлага болгон бэлтгэн нийлүүлэгч, зээлдүүлэгчээс бараа, ажил, үйлчилгээ болон хэлцлээс хүлээгдэж буй мөнгөн төлбөрийн шаардах эрхээ шилжүүлэх, энэхүү эрхийг хүлээн авагч нь бэлтгэн нийлүүлэгч, зээлдүүлэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх, худалдан авагч, зээлдэгчээс нэхэмжлэлийн дагуу шаардах эрхээ хэрэгжүүлэх;

2.2.2.факторингийн үйл ажиллагаа нь баталгаатай буюу буцаан дуудах нөхцөлтэй, баталгаагүй буюу буцаан дуудах нөхцөлгүй, урвуу гэсэн төрөлтэй байх;

2.2.3.буцаан дуудах нөхцөлтэй факторингийн үед үүрэг гүйцэтгэгчийн төлбөрийн чадварын эрсдэлийг бэлтгэн нийлүүлэгч, зээлдүүлэгч тал хариуцах ба нэхэмжлэлийн шаардлагыг хангаагүй тохиолдолд факторингийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс шаардах эрхийг бэлтгэн нийлүүлэгч, зээлдүүлэгчид буцаан шилжүүлэх;

2.2.4.буцаан дуудах нөхцөлгүй факторингийн үед үүрэг гүйцэтгэгчийн төлбөрийн чадварын эрсдэлийг факторингийн үйл ажиллагаа эрхлэх этгээд, шаардах эрхийн доголдолгүй болохыг бэлтгэн нийлүүлэгч, зээлдүүлэгч тал тус тус хариуцах;

2.2.5.урвуу факторингийн үед факторингийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь үүрэг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр мөнгөн төлбөрийн үүргийг бэлтгэн нийлүүлэгч, зээлдүүлэгчийн өмнө хариуцах ба энэ тохиолдолд бэлтгэн нийлүүлэгч, зээлдүүлэгчийн зөвшөөрлийг авсан байх;

2.2.6.бэлтгэн нийлүүлэгч, зээлдүүлэгч нь факторингийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд шаардах эрхээ шилжүүлсэн талаарх мэдэгдэл, нэхэмжлэлийг баталгаажуулсан болон харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой баримт бичгийг хүргүүлэх ба үүрэг гүйцэтгэгч нь факторингийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг хүлээн зөвшөөрсөн байх;

2.2.7.факторингийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь шаардах эрхийг хүлээн авахдаа бэлтгэн нийлүүлэгч, зээлдүүлэгчийн санхүүгийн байдал, төлбөрийн чадвар, зах зээлийн нөхцөл, өрсөлдөх чадварыг үнэлсэн байх;

2.2.8.факторингийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь бэлтгэн нийлүүлэгч, зээлдүүлэгчээс шаардах эрхийг хүлээн авч, мөнгөн төлбөрийг саадгүй, бүхэлд нь хэрэгжүүлэх ба тэдгээрийг шүүх, прокурор, авилгатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллага зэрэг гуравдагч этгээдийн өмнө бүрэн төлөөлнө.

2.2.9.факторингийн гэрээгээр авсан авлагыг давхар бусад факторингийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд шилжүүлэхгүй байх;

2.2.10.үүрэг гүйцэтгэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг үндэслэлгүйгээр ихэсгэхгүй байх;

2.2.11.факторингийн гэрээгээр шилжүүлэн авсан авлагын тухай мэдэгдлийг Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасны дагуу бүртгүүлж болно.

2.3.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс төлбөрийн баталгаа гаргахад Иргэний хуулийн 234, 457, 458 дугаар зүйлийг баримтална.

2.4.Банк бус санхүүгийн итгэлцлийн үйл ажиллагаанд дараах шаардлагыг тавина:

2.4.1.өөрийн хөрөнгийг итгэлцлийн үйлчилгээ эрхлэгчид шилжүүлж, түүнээс гарах үр шимийг өөрөө хүртэх, эсхүл хувь хүртэгчид хүртээх зорилго бүхий иргэн, хуулийн этгээд (цаашид “итгэмжлэгч” гэх)-ийн актив хөрөнгийг итгэлцлийн үйлчилгээний хүрээнд хянах, ашиглах, захиран зарцуулах доод хугацаа зургаан сараас доошгүй байх ба Иргэний хуулийн 406.3-т заасны дагуу итгэмжлэгч гэрээнээс үүсэх аливаа эрсдэлийг хүлээж, үр шимийг хүртэх;

2.4.2.итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч болон итгэмжлэгч харилцан тохиролцож Хөрөнгө итгэмжлэх гэрээг бичгээр байгуулсан байх;

2.4.3.харилцагчийг татах зорилгоор бэлэг, урамшуулал санал болгох, хүүгийн зөрүүнээс ашиг олох зорилгоор итгэлцлээр хөрөнгө байршуулахыг ятгах, өөрийн үйл ажиллагааны үр дүнг худал мэдээлэх, харилцагчийн хувийн мэдээлэл задруулах болон төөрөгдөлд оруулахуйц аливаа үйлдэл гаргахгүй байх;

2.4.4.үр шимийн хувь хэмжээг өөрсдийн харилцагч дунд хаалттай хүрээнд зарлаж болох ба аливаа хэлбэрээр олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан түгээхгүй байх;

2.4.5.тусгай зөвшөөрлийг итгэлцлийн үр шимийн үнэ цэнийн баталгаа болгон ашиглах, эсхүл үр шимийн баталгаа гаргах, итгэмжлэгчийн хүсэл зоригийн эсрэг өөрсдийн нөхцөл, шаардлагыг тулгах зэргээр итгэмжлэгчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулахгүй байх;

2.4.6.итгэмжилсэн хөрөнгийг Хөрөнгө итгэмжлэх гэрээгээр тогтоосон нөхцөлийг зөрчиж бусад этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

2.4.7.гэрээний дагуу итгэмжлэгдсэн хөрөнгийг захиран зарцуулах үйл ажиллагаатай холбогдох бүртгэл, тайлан болон бусад шаардсан мэдээллийг итгэмжлэгчид үнэн зөв гаргаж өгөх, итгэмжлэгчээс шилжүүлэх мөнгөн хөрөнгийн гарал үүслийг тодорхойлох ажиллагааг хэрэгжүүлэх;

2.4.8.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх дүрэм, журам, компанийн засаглалын кодекст заасан холбогдох шаардлагыг хангах.

2.5.Банк бус санхүүгийн богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаанд дараах шаардлагыг тавина:

2.5.1.төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа алдагдуулахгүйгээр Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан санхүүгийн хэрэгсэл, Засгийн газар болон Төв банкны үнэт цаасанд хөрөнгө оруулах;

2.5.2.гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийн эх үүсвэрийг нэг жил хүртэл хугацаатай энэ журмын 2.5.1-г заасан санхүүгийн хэрэгсэлд хөрвүүлэх;

2.5.3.иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийн эх үүсвэрийг гэрээний үндсэн дээр хөрвүүлэхдээ хөрөнгө оруулалтын хэлбэр, хүртэх үр шим, эрсдэлийг харилцан тохиролцсон байх;

2.5.4.өөрийн эзэмшиж буй үнэт цаасыг арилжааны зөрүүгээс ашиг олох зорилгоор худалдаж болно.

2.6.Өөрийн хөрөнгөөр буюу бусдаас аливаа хэлбэрээр эх үүсвэр татан төвлөрүүлээгүй банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувьд энэ журмын 2.5 дахь хэсэг хамаарахгүй.

2.7.Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаанд дараах шаардлагыг тавина:

2.7.1.ажлын байрны аюулгүй байдлыг хангасан байх;

2.7.2.санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгоор дүрс бичлэгийн техник хэрэгсэлтэй байх ба дүрс бичлэгийг нэг сараас доошгүй хугацаагаар архивлан хадгалдаг хяналтын системтэй байх;

2.7.3.валют шалгагч болон мөнгө тоологч машинтай байх;

2.7.4.валютыг худалдан авах, худалдах ханшийг электрон самбар болон цахим талбараар нийтэд ил тод мэдээлдэг байх;

2.7.5.Стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан шаардлагыг хангасан хаягтай байх;

2.7.6.ажилтан нь мөнгөн тэмдэгтийг тухай бүр хянах бөгөөд гүйлгээнээс хуурамч мөнгөн тэмдэгт илрүүлсэн тохиолдолд гүйлгээг зогсоож, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэн, биеийн байцаалтын мэдээллийн хамт холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгөх;

2.7.7.хуульд зааснаас бусад үндэслэлээр харилцагчийн мэдээллийг бусдад өгөх, задруулах эсхүл хувийн зорилгоор ашиглахгүй байх;

2.7.8.үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй хаягнаас өөр байршилд гадаад валют худалдах, худалдан авах, харилцагчаас захиалга авах зорилго бүхий зөвшөөрөлгүй этгээдтэй шууд болон шууд бусаар хамтран ажиллахгүй байх;

2.7.9.гадаад валютын арилжаа дагнан эрхлэх хуулийн этгээдийн үндсэн болон салбар нэгжийн хаяг байршил нь нэг гудамж, талбайд давхцахгүй байх;

2.7.10.гадаад валютын арилжаа дагнан эрхлэх хуулийн этгээд гадаад валютын үлдэгдлийг зориудаар идэвхгүй төлөвт байлгаж, зохиомлоор валютын хомсдол үүсгэх зорилгоор худал мэдээлэл тараах, валют худалдах, худалдан авах гүйлгээ хийхгүй байх.

2.8.Бэлэн бусаар гадаад валютын арилжаа эрхлэх хуулийн этгээдийн хувьд энэ журмын 2.7.2-2.7.4 дэх заалт хамаарахгүй.

2.9.Дээд зэрэглэлийн 5 ба 4 одтой зочид буудал нь өөрийн үйлчлүүлэгч болох Монгол Улсад жуулчлал хийж байгаа нэг гадаадын иргэнд өдөрт 3 сая төгрөгөөс ихгүй дүнгээр гадаад валют худалдан авах, худалдахад энэхүү журмын 2.8 дахь хэсэг хамаарахгүй.

2.10.Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, үйл ажиллагаа эрхлэх үндсэн болон салбар нэгжийн байршилд өөрчлөлт оруулах тохиолдолд зөвшөөрөл эзэмшигч нь холбогдох шаардлагыг хангасан талаарх баримтыг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлнэ.

2.11.Санхүүгийн зохицуулах хорооноос энэ журмын 2.10-д заасан баримтыг хүлээн авсанаас хойш ажлын 5 хоногийн дотор цахимаар зөвшөөрөл эзэмшигчид хариуг хүргүүлнэ.

2.12.Энэ журамд заасан банк бус санхүүгийн үйл ажиллагааны баримт бичгийг бүрдүүлэх, хүлээн авах зааврыг баталж болно.

ГУРАВ. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ

3.1.Банк бус санхүүгийн байгууллага нь дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллана:

3.1.1.өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт;

3.1.2.төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт;

3.1.3.актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт;

3.1.4.гадаад валютын ханшийн эрсдэлийн үзүүлэлт;

3.1.5.бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлт;

3.1.6.үндсэн хөрөнгийн үзүүлэлт.

3.2.Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг банк бус санхүүгийн байгууллагад 3.1.3, 3.1.4, итгэлцлийн үйл ажиллагаанаас бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг банк бус санхүүгийн байгууллагад 3.22.1, 3.22.2-д заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хамаарахгүй.

3.3.Хөрөнгө (актив)-ийн өгөөжийг тооцохдоо тайлант үеийн татварын дараах цэвэр ашгийг нийт активын дундаж (өмнөх оны мөн үеийн актив дүн дээр тайлант үеийн активын дүнг нэмж дундчилсан дүн)-тай, өөрийн хөрөнгийн өгөөжийг тооцохдоо тайлант үеийн татварын дараах цэвэр ашгийг өөрийн хөрөнгийн дундаж(өмнө оны мөн үеийн өөрийн хөрөнгө дээр тайлант үеийн өөрийн хөрөнгийг нэмж дундчилсан дүн)-тай харьцуулах замаар тус тус тооцно.

3.4.Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт нь банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй байгаа эсэхийг тодорхойлсон үнэлгээг илэрхийлэх ба дараах зохистой харьцааг үндэслэн тодорхойлно:

3.4.1.нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн нийт активд харьцуулсан харьцаа нь 10 хувиас доошгүй;

3.4.2.өөрийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн нийт активд харьцуулсан харьцаа нь 20 хувиас доошгүй;

3.4.3.итгэлцлийн үйлчилгээгээр эх үүсвэр татан төвлөрүүлсэн ББСБ-ын өөрийн хөрөнгийг нийт активаас гадаадын банк, санхүүгийн байгууллагаас татсан зээлийн эх үүсвэрийг хассан активт харьцуулсан харьцаа 30 хувиас доошгүй байх;

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан/

3.4.4.итгэлцлийн үйлчилгээнээс бусад хэлбэрээр эх үүсвэр татан төвлөрүүлсэн ББСБ-ын өөрийн хөрөнгийг нийт активаас гадаадын банк, санхүүгийн байгууллагаас татсан зээлийн эх үүсвэрийг хассан активт харьцуулсан харьцаа 20 хувиас доошгүй байх;

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан/

3.4.5.бусдаас эх үүсвэр аливаа хэлбэрээр татан төвлөрүүлээгүй ББСБ-ын өөрийн хөрөнгийг нийт активаас гадаадын банк, санхүүгийн байгууллагаас татсан зээлийн эх үүсвэрийг хассан активт харьцуулсан харьцаа 10 хувиас доошгүй байх.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан/

3.5.Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө дараах бүрэлдэхүүнтэй байна:

3.5.1.энгийн хувьцаа;

3.5.2.халаасны хувьцаа;

3.5.3.энгийн хувьцаанаас нэмж төлөгдсөн капитал;

3.5.4.цэвэр ашгаас байгуулсан нөөцийн сан;

3.5.5.хуримтлагдсан ашиг, алдагдал;

3.5.6.хандивын капитал.

3.6.Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө дараах бүрэлдэхүүнтэй байна:

3.6.1.давуу эрхийн хувьцаа;

3.6.2.давуу эрхийн хувьцаанаас нэмж төлөгдсөн капитал;

3.6.3.дахин үнэлгээний нэмэгдэл;

3.6.4.нийгмийн хөгжлийн сан;

3.6.5.дахин үнэлгээний сан;

3.6.6.хоёрдогч өглөг.

3.7.Банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн нийлбэрээр тооцно.

3.8.Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг тооцохдоо өөрийн хөрөнгийн дүнг дараах байдлаар тохируулсан байна.

3.8.1.хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүн нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүнгээс хэтрэхгүй байх, хэтэрсэн дүнг өөрийн хөрөнгийн дүнгээс хасах;

3.8.2.зайны болон газар дээрх хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчил, дутагдалтай холбоотой залруулгын гүйлгээг зохих дансанд бүртгэж, өөрийн хөрөнгийг хорогдуулах буюу нэмэгдүүлэн бодит дүнг гаргах.

3.9.Эрсдэлээр жигнэсэн нийт актив дараах бүрэлдэхүүнтэй байна:

3.9.1.эрсдэлээр жигнэсэн актив;

3.9.2.эрсдэлээр жигнэсэн бусдын өмнө хүлээж болзошгүй үүрэг;

3.9.3.гадаад валютын ханшийн жигнэсэн актив;

3.9.4.үйл ажиллагааны эрсдэлээр жигнэсэн актив

3.10.Эрсдэлээр жигнэсэн нийт активын дүнг тооцохдоо тэнцлийн актив, тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргийн дүнг энэ журмын 1 дүгээр хавсралтад тусгасан эрсдэлийн хувиар үржүүлж гаргах бөгөөд дараах зарчмыг баримтална:

3.10.1.гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж, харилцахын эрсдэлийн хувь хэмжээг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл тогтоох байгууллагаас тогтоосон рейтингийг ашиглан дараах хүснэгтийг үндэслэн тооцно:

Стандарт энд Пурс	AAA/AA-	A+/A-	BBB+/BBB-	BB+/B-	B- бага	Рейтинггүй банк
Фич						
Мууди	Aaa/Aa3	A1/A3	Baa1/Baa3	Ba1/B3	B- бага	
Урт хугацаат авлага (3 сараас дээш)	20%	50%	50%	100%	150%	100%
Богино хугацаат авлага (3 сараас доош)	20%	20%	20%	50%	150%	100%

3.10.2.гадаад валютын ханшийн эрсдэлээс хүлээж болзошгүй алдагдлыг тооцохдоо тэнцлийн гадаад валютын активын үлдэгдэл, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээр үүсэж болзошгүй гадаад валютын авлагын нийлбэрээс тэнцлийн гадаад валютын пассивын үлдэгдэл, тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа гэрээ, хэлцлээр үүсэж болзошгүй гадаад валютын өглөгийн нийлбэрийг хасч тооцно.

3.10.3.үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэхийн тулд сүүлийн 3 жилийн татварын өмнөх эерэг ашгийн дунджийн 15 хувийг өөрийн хөрөнгийн шаардлагын урвуугаар үржүүлэн нэмнэ.

3.11.Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг харилцагчийн анхны шаардлагаар буцаан олгох чадварыг илэрхийлэх бөгөөд түргэн борлогдох активын дүнг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүнд харьцуулж тооцох бөгөөд төгрөг, гадаад валют болон тэдгээрийн нийлбэр дүнгээр тус тус тодорхойлох ба энэхүү зохистой харьцаа нь 8 хувиас доошгүй байна.

3.12.Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг тооцохдоо дараах байдлаар тохируулна:

3.12.1.түргэн борлогдох активыг касс дахь бэлэн мөнгө, банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж, харилцах дансны үлдэгдэл, Засгийн газрын үнэт цаасны нийлбэрээр;

3.12.2.бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг нийт өр төлбөрийн дүнгээс 1 жилээс дээш урт хугацаат өр төлбөрийг хасаж тооцно.

3.13.Зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг хангаж ажилласанд тооцно.

3.14.Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт нь тухайн активыг нэг этгээдэд их хэмжээгээр төвлөрүүлснээр хүү, төлбөрийг эргүүлэн төлж чадахгүйд хүрэх, улмаар банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн чадвар муудахаас урьдчилан сэргийлэх зорилготой ба дараах зохистой харьцааг тооцно:

3.14.1.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.1-13.3-д заасан зохистой харьцааны үзүүлэлтээр;

3.14.2.банк бус санхүүгийн байгууллагын худалдан авах үнэт цаасны эзэмшлийн нийт дүн нь өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтрэхгүй;

3.14.2.1.үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын “I”, “II” ангилалын компанийн хувьцаанд хөрөнгө оруулж болох ба худалдан авсан компанийн хувьцааны нийт дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй бөгөөд энэ нь нэг компанийн гаргасан хувьцааны нийт дүнгийн 20 хувиас дээшгүй байх;

3.14.2.2.компанийн өрийн бичиг худалдан авах нийт дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй;

3.14.2.3.бусад үнэт цаас худалдан авах нийт дүн нь өөрийн хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй.

3.15.Хөрөнгө (актив)-ийн эрсдэлийн сангийн зохистой харьцаа буюу зээл, үнэт цаас, хүлээж болзошгүй үүрэг, бусад активын эрсдэлийн санг энэ журмын 4 дүгээр бүлэгт заасны дагуу тооцож, байгуулна.

3.16.Гадаад валютын ханшийн эрсдэлийн үзүүлэлт нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш хэлбэлзэхэд алдагдал хүлээх эрсдэлийг илэрхийлэх ба гадаад валютын актив пассивын зохистой харьцаа нь нийт болон нэгж валютын хувьд өөрийн хөрөнгийн +/-40 хувиас хэтрэхгүй.

3.17.Гадаад валютын эрсдэлийг тэнцлийн болон тэнцлийн гадуурх дансанд бүртгэлтэй нийт гадаад валютын актив, пассивын зөрүүг өөрийн хөрөнгөнд харьцуулан тооцно.

3.18.Гадаад актив дараах бүрэлдэхүүнтэй байна:

3.18.1.гадаад валютын харилцах, хадгаламж, касс дахь бэлэн валют;

3.18.2.гадаад валютаар илэрхийлэгдсэн зээл, түүнтэй адилтган тооцох актив;

3.18.3.бусад актив.

3.19.Гадаад пассив дараах бүрэлдэхүүнтэй байна:

3.19.1.гадаад валютаар илэрхийлэгдсэн итгэлцлийн үйлчилгээний өглөг;

3.19.2.бусдаас авсан зээл;

3.19.3.төслийн зээл;

3.19.4.гаргасан өрийн бичиг;

3.19.5.бусад өглөг.

3.20.Тэнцлийн гадуурх дансны үлдэгдэлд гадаад валютаар гаргасан бүх төрлийн төлбөрийн баталгаанууд хамаарна.

3.21.Гадаад валютаар илэрхийлэгдэх актив хөрөнгөгүй, гадаад валютаар бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлээгүй банк бус санхүүгийн байгууллагын хувьд гадаад валютын ханшийн эрсдэлийн үзүүлэлтийг тооцохгүйгээр хангаж ажилласан гэж үзнэ.

3.22.Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлт нь бусдаас татан төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг үр ашигтай удирдах, эрсдэлийг бууруулах зорилготой ба дараах зохистой харьцааг тооцно:

3.22.1.итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 60 хувиас хэтрэхгүй;

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.22.2.тайлант үеийн цэвэр ашгийн 3 хувиас доошгүй хувиар итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн эх үүсвэрт нөөцийн сан байгуулах ба уг сангийн хэмжээ итгэлцлээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн 10 хувьтай тэнцүү байх;

3.22.3.гаргасан өрийн бичгийг өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа нь 30 хувиас хэтрэхгүй. Хувьцаат компани нь өрийн бичгийг гаргахдаа Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хэрэгжүүлэх;

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.22.4.дотоодын арилжааны банк, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдээс зээл болон бусад хэлбэрээр эх үүсвэр татан төвлөрүүлэхгүй байх;

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор нэмсэн/

3.22.5.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлэх дүн нь өөрийн хөрөнгийн 60 хувиас хэтрэхгүй байх.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор нэмсэн/

3.23.Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ногоон зээлийн багц нь тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономийн шаардлагыг хангасан, байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцоо, уур амьсгалын эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн, санхүүгийн тайланд тогтвортой байдлын болон уур амьсгалын өөрчлөлтийн стандартын дагуу тайлагнадаг ББСБ-ын хувьд банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлэх эх үүсвэрийг дараах байдлаар тооцно:

3.23.1.нийт зээлийн багцад эзлэх ногоон зээлийн хэмжээ 2-3 хувь бол итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 65 хувиас хэтрэхгүй;

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.23.2.нийт зээлийн багцад эзлэх ногоон зээлийн хэмжээ 3-4 хувь бол итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 70 хувиас хэтрэхгүй;

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.23.3.нийт зээлийн багцад эзлэх ногоон зээлийн хэмжээ 4-5 хувь бол итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 75 хувиас хэтрэхгүй;

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.23.4.нийт зээлийн багцад эзлэх ногоон зээлийн хэмжээ 5 хувиас дээш бол итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 80 хувиас хэтрэхгүй;

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.24.Үндсэн хөрөнгийн зохистой харьцааг тооцохдоо цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн дүнг нийт хөрөнгөнд харьцуулж тооцох бөгөөд энэхүү зохистой харьцаа нь 15 хувиас хэтрэхгүй байна.

3.25.Банк бус санхүүгийн байгууллага нь энэ журмын нэгдүгээр хавсралтаар баталсан зохистой харьцааны тайланг улирал бүр гаргаж, дараа улирлын эхний сарын 08-ны өдрийн дотор Хороонд цахимаар ирүүлнэ.

~~3.26.Итгэлцлийн үйлчилгээний зөвшөөрөлтэй банк бус санхүүгийн байгууллага нь энэ журмын нэгдүгээр хавсралтаар баталсан зохистой харьцааны тайланг сар бүр гаргаж, дараа сарын 08-ны өдрийн дотор Хороонд цахимаар ирүүлнэ.~~

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор хассан/

3.27.Банк бус санхүүгийн байгууллага нь дараах мэдээг сар бүрд харгалзах ажил гүйлгээний дүнгээр гаргаж, дараа сарын 08-ны өдрийн дотор Хороонд цахимаар ирүүлнэ:

3.27.1.зээл олголт, эргэн төлөлт, зээлийн зориулалт, хүүгийн судалгааны мэдээ;

3.27.2.цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний мэдээ;

3.27.3.сар тутмын валют арилжааны мэдээ;

3.27.4.банк, санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөр, бусад эх үүсвэрээс татсан зээлийн мэдээ.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор нэмсэн/

ДӨРӨВ. АКТИВЫГ АНГИЛАХ, АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛЖ, ЗАРЦУУЛАХ

4.1.Банк бус санхүүгийн байгууллага нь энэ журмын дагуу зээл, факторинг, үнэт цаас (1 жил хүртэлх хугацаатай Монголбанкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цааснаас бусад үнэт цаас), өмчлөх бусад хөрөнгө, авлага(цаашид “актив” гэх)-ыг ангилах, тэдгээрт учирч болзошгүй алдагдлаас хамгаалах эрсдэлийн санг байгуулж, зарцуулна.

4.2.Зээлийн эрсдэлийн сангийн зардлыг Ажахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.11-д заасны дагуу албан татвар ногдох орлогоос хасаж тооцох бөгөөд факторинг, үнэт цаас, өмчлөх бусад хөрөнгө, авлагын ангилалд байгуулсан эрсдэлийн сангийн зардал нь албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд хамаарахгүй.

4.3.Активыг дор дурдсан хугацааны үзүүлэлтээр тоочон ангилж, эрсдэлийн санг байгуулна:

Ангилал	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Зээл, факторинг	30 хоног хүртэл	31-90	91-180	181-360	361-ээс дээш хоног үндсэн төлбөр, хүүгийн төлбөр хийгдээгүй
Хувьцаа болон түүнтэй адилтган тооцох үнэт цааснаас бусад үнэт цаас	15 хоног хүртэл	30 хоног хүртэл	31-60	61-90	91-ээс дээш хоног үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдээгүй
Өмчлөх бусад хөрөнгө	30 хоног хүртэл	31-60	61-90	91-120	121-ээс дээш хоног борлогдоогүй
Авлага	30 хоног хүртэл	31-60	61-90	91-120	121-ээс дээш хоног төлөгдөөгүй буюу, гэмт хэргийн улмаас бий болсон авлага

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

4.4. Банк бус санхүүгийн байгууллага нь дотооддоо хийсэн активын эрсдэлийн үнэлгээ, дүгнэлт, тэдгээртэй холбогдох нотлох баримтад үндэслэн чанарын үзүүлэлтийг харгалзан активын ангилалд өөрчлөлт оруулж болох ба чанарын үзүүлэлтийг СТОУС-д нийцүүлэн дотооддоо тогтоож, мөрдүүлнэ.

4.5. Төлбөр хариуцагч нь зээл, факторинг, үнэт цаас, өмчлөх бусад хөрөнгө, авлага хэлбэрээр үүссэн хөрөнгө буюу актив, активыг банк бус санхүүгийн байгууллагад төлж барагдуулах үүрэг хүлээсэн этгээд байна.

4.6. ББСБ нь активыг дор дурдсан байдлаар тухай бүр ангилна:

4.6.1. Хэвийн;

4.6.2. Анхаарал хандуулах;

4.6.3. Чанаргүй:

4.6.3.1. хэвийн бус;

4.6.3.2. эргэлзээтэй;

4.6.3.3. муу.

4.7. Төлбөр хариуцагчийн төлбөрийн чадвар алдагдсан, дампуурсан үед барьцаанд тавьсан эд хөрөнгийн тухайн үеийн үнэлгээ нь активын үндсэн өр болон хүүгийн 75-аас доошгүй хувийг төлж барагдуулахад хангалттай тохиолдолд эргэлзээтэй ангилалд, хангалтгүй тохиолдолд муу ангилалд хугацаа харгалзалгүй ангилна.

4.8. Банк бус санхүүгийн байгууллага нь төлбөр хариуцагчаас зээлийг хугацаа хэтэрсэн өдрөөс хойш 30 хүртэл хоногт багтаан эргэн төлөх боломжтой гэж дүгнэсэн тохиолдолд тухайн зээлийг хэвийн ангилалд бүртгэх ба 31 дэх хоногоос эхлэн тус зээлийг энэ журамд заасны дагуу ангилал бууруулан тогтооно.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

4.9. Гэмт хэргийн шинж чанартай үйлдлээс үүссэн байж болзошгүй шалтгаанаар төрийн эрх бүхий байгууллагад шалгагдаж байгаа активт 100 хувь эрсдэлийн сан байгуулна.

4.10. Активын гэрээний хугацааг нэг удаа сунгасан бол ангиллыг хэвээр хадгална, харин хоёр болон түүнээс дээш сунгасан бол өмнөх ангиллаас нэг шатлалаар бууруулж болно.

4.11.Төлбөр хариуцагчийн санхүүгийн чадвар муудсан болон анхны гэрээ, хэлцлийн дагуу төлбөр хийх чадваргүй болсноос шалтгаалан актив төлөгдөх хугацааг сунгасан, банк бус санхүүгийн байгууллагаас төлбөрийг нь төлүүлэхээр төрийн эрх бүхий байгууллагад нэхэмжлэл гаргасан байгаа активт энэ журмын 4.10 дахь хэсэг хамаарахгүй.

4.12.зээлийн мэдээллийн санд нийлүүлэх зээлдэгчийн талаарх мэдээлэлдээ тухайн активын ангилал, түүний өөрчлөлтийг тухай бүр журмын дагуу үнэн зөв тусгасан байна.

4.13.ББСБ энэхүү журмын 4.6.2, 4.6.3-т заасан активын ангиллыг дараах нөхцөлүүдийн 2 нөхцөл нь зэрэг бүрдсэн тохиолдолд активын ангиллыг шатлал үл харгалзан хэвийн ангилал хүртэл дээшлүүлнэ:

4.13.1.төлбөр хариуцагч нь 90-ээс дээш хоног хугацаа хэтэрсэн төлбөргүй;

4.13.2.сүүлийн дараалсан 3 удаагийн эргэн төлөлтийг хугацаанд нь тогтмол хийсэн;

4.13.3.төлбөр хариуцагчийн санхүү, төлбөрийн чадварын нөхцөл байдал сайжирснаар активыг анхны эсвэл шинэ гэрээний нөхцөлийн дагуу бүхэлд нь төлж барагдуулах магадлал нэмэгдсэн;

4.13.4.Санхүүгийн зохицуулах хорооноос хийсэн хяналт шалгалтын үнэлгээнд үндэслэн эцсийн ангиллыг дээшлүүлэхээр зөвшөөрсөн актив.

